

19 Түүний үйлсийн тухай эш үзүүлэг

19.1 Мосегийн хууль, зөвтийн шаардлагыг биелүүлэх нь

¹⁷Хуулийг эсвэл Эш үзүүлэгчдийг хэрэгсэхгүй болгохоор Намайг ирсэн гэж бүү бод. Хэрэгсэхгүй болгохын тулд бус, харин гүйцэлдүүлэхийн тулд Би ирсэн юм. ¹⁸Үнэнээр Би та нарт хэлье, тэнгэр газрыг алга болтол, бүгд биелэгдтэл Хуулиас ганц ч үсэг, ганц ч зураас алга болохгүй. ¹⁹Хэн боловч эдгээр тушаалуудаас хамгийн өчүүхнийг нь ч үл тоомсорлож, бусдад тийн сургавал тэнгэрийн хаанчлалд хамгийн өчүүхэн нэгэн гэгдэх болно. Харин хэн боловч тэдгээрийг сахиж, сургавал тэнгэрийн хаанчлалд агуу нэгэн гэгдэх болно. ²⁰Би та нарт хэлье, хэрэв та нарын зөвт байдал чинь фарисайчууд болон хуулийн багш нараас илүү гарахгүй л бол, та нар тэнгэрийн хаанчлалд орохгүй.
(Матай 5:17-20 АБ 2004)

[] Есүс хуулийн дагуу юу хийж гүйцэтгэснийг та мэдэх үү?

[] Та Бурханы оршихуйд нэвтрэхээр чадваржсан уу?

19.2 Тослогоо

²ЭЗЭНий Сүнс, мэргэн ухаан болон ойлголтын сүнс, зөвлөх болон хүч чадлын сүнс, ЭЗЭНээс эмээхүй болон мэдлэгийн сүнс Түүн дээр оршино. (Исаиа 11:2 АБ 2004)

Ариун сүнсээр тослогдсон ¹³Тэгээд Есүс Иоханаар баптисм хүртэхийн тулд Галилаас Иорданд түүн дээр ирэв. ¹⁴Харин Иохан -Би Танаар баптисм хүртэх учиртай байтал Та над уруу ирнэ үү? гээд, Түүнийг болиулахыг оролдтол, ¹⁵Есүс хариуд нь -Энэ удаад үүнийг зөвшөөр. Ингэснээрээ аливаа зөвт байдлыг гүйцэлдүүлэх нь бидэнд зохицож байна гэж хэлэхэд тэр Түүнд зөвшөөрөв. ¹⁶Есүс баптисм хүртээд, голын уснаас тэр даруй гарах үед тэнгэр заагдаж, Бурханы Сүнс тагтаа лугаа адил бууж, Түүн дээр ирэхийг тэр харав. ¹⁷Тэнгэрээс -Энэ бол Миний хайрт Хүү. Түүнд Миний таалал оршдог гэх дуу гарлаа. (Матай 3:13-17 АБ 2004)

- Та ариун сүнсээр баптисм хүртсэн үү?
- Ариун сүнсээр зааж чадах уу?

⁸Харин Ариун Сүнс та нар дээр ирэхэд, та нар хүчийг олж, тэгээд Иерусалим, бүх Иудей, Самари тэр байтугай энэ дэлхийн хязгаар хүртэл Намайг гэрчлэх болно гэв. (Үйлс 1:8 АБ 2004)

[] Та сайн мэдээг хуваалцах чин хүсэлтэй юу?

19.3 Дудран унасан нь

⁹Сионы охин оо, үлэмж ихээр баярлагтун! Иерусалимын охин оо! Ялалтын уухай хадаагтун! Үзэгтүн, хаан чинь чам уруу очиж байна. Тэр бол зөв шударга, ялагдашгүй, даруу бөгөөд илжиг унажээ. Илжигний унага болох дудран унажээ. (Зехариа 9:9 АБ 2004)

⁴Энэ нь эш үзүүлэгчээр хэлүүлсэн нь биелэгдэхийн тул болой. Юу гэвэл ⁵“Сионы охинд хэл. “Харагтун, чиний Хаан чам уруу ирж явна. Илжиг буюу ачаа зөөдөг амьтны төл дудран унаж, эгэл даруухнаар ирнэ”” ⁶Тэгээд шавь нар явж Есүсийн захисан ёсоор гүйцэтгэж, ⁷илжгийг дудрантай нь авчрахад тэд дээр нь дээлүүдээ тохоцгоолоо. Есүс илжгийг унав. ⁸Цугласан хүмүүсийн ихэнх нь дээл хувцсаа зам дээр дэвсэхэд, зарим нь модноос мөчир огтлон зам дээр тавьж байлаа. ⁹Түүний өмнө хойно нь явж буй хурсан олон - Давидын Хүүд Хосанна! Эзэний нэрээр Ирэгч нь ерөөлтэй ээ! Хамгийн дээдэд Хосанна! ¹⁰Түүнийг Иерусалимд ороход бүх хотынхон үймэлдэж, -Энэ хэн билээ? гэцгээв. ¹¹Олон түмэн - Энэ чинь Галилын Назараас ирсэн эш үзүүлэгч Есүс байгаа юм гэж байв. (Матай 21:4-11 АБ 2004)

¹²Маргааш нь баярт ирсэн үй олон хүн Есүсийг Иерусалим уруу ирж явааг сонсоод, ¹³далдуу модны мөчрийг барьж, Түүнийг угтахаар гарч, -Хосанна! Эзэний нэрээр Ирэгч, Израилийн Хаан ерөөлтэй ээ! гэж хашхиралдаж байлаа. ¹⁴Есүс залуу илжиг олж унасан байв. Энэ нь ¹⁵“Сионы

охин оо, бүү ай! Харагтун, Хаан чинь илжигний дудран унаад ирж байна” гэж бичигдсэнчлэн болов. ¹⁶Шавь нар нь эдгээр зүйлсийг анхандаа ойлгоогүй ажээ. Харин Есүсийг алдарших үед эдгээр нь Түүний тухай бичсэн байсныг, мөн хүмүүс Түүнд эдгээрийг үйлдсэн гэдгийг нь санажээ. ¹⁷Есүс Лазарыг булшнаас дуудаж, үхэгсдээс амилуулахад нь Түүнтэй хамт байсан олон түмэн Есүсийг гэрчилж байлаа. ¹⁸Тиймээс олон түмэн Есүсийн эдгээр тэмдгийг үйлдсэнийг сонссон тул Түүнийг угтав. ¹⁹Тэгтэл фарисайчууд өөр хоорондоо -Хараач, та нарын үйлс ямар ч ашиг алга. Харцгаа, Түүний араас бүгд дагалаа гэцгээв. (Иохан 12:12-19 АБ 2004)

[] Түүхэн дэх "нигүүлслийн" энэ үед Хаадын Хаан яагаад илжиг унах болсныг та мэдэх үү?

19.4 Тааламжит жил

¹Эзэн БУРХАНЫ Сүнс миний дээр байна. Учир нь ЭЗЭН намайг зовогсдод сайн мэдээг дэлгэрүүлэхийн тулд томилсон юм. Тэр намайг шаналсан зүрхтэй хүмүүсийг эдгээн, олзлогдогсдод эрх чөлөөг тунхаглаж, хүлээстэй хүмүүсийг чөлөөлөхийн тулд, ²мөн ЭЗЭНий тааламжит жил, бидний Бурханы өшөө авах өдрийг тунхаглан, бүх гашуудагчийг тайвшруулан, ³Сионд гашуудагсдад үнсний оронд цэцгийн хэлхээг өгч, гашуудлын оронд баяр хөөрийн тос, гаслант сүнсний оронд магтаалын хувцас соёрхохын тулд илгээсэн юм. Иймээс Түүнийг алдаршуулахын тулд тэднийг үнэн зөвийн царснууд, ЭЗЭНий суулгац гэж нэрлэх болно. (Исаиа 61:1- 3 АБ 2004)

[] Та Ариун сүнсний баптисм хүртсэний дараа юу хийх ёстойгоо мэддэг үү?

19.5 Нүглийг нэг өдөрт арилгах

⁹Иошуагийн өмнө Миний тавьсан чулууг үзэгтүн. Нэг чулуун дээр долоон нүд. Үзэгтүн, Би түүн дээр бичээс сийлнэ” гэж

түмэн цэргийн ЭЗЭН тунхаглаад “Танц өдрийн дотор тэр газрын гэм бурууг Би зайлуулна.(Зехариа 3:9 АБ 2004)

⁴Тэнгэр элч өөрийнхөө өмнө зогсогчдод хандан -Түүнээс бузар муу хувцсыг нь тайлан ав гээд түүнд дахин -Харагтун, Би чиний гэм бурууг чамаас авч, ёслолын дээлээр чамайг хувцаслана гэв. ⁵Дараа нь би -Түүний толгой дээр тэд цэвэр малгай тавиг гэсэнд тэд ЭЗЭНий тэнгэр элчийг зогсож байх зуур түүний толгой дээр цэвэр малгай тавьж, түүнд хувцас өмсгөв.

⁶ЭЗЭНий тэнгэр элч Иошуад сануулан ⁷-Түмэн цэргийн ЭЗЭН ийн айлдаж байна. “Хэрэв чи Миний замаар алхаж, Миний үйлчлэлийг гүйцэтгэвэл чи мөн Миний гэрийг захирч, мөн Миний шүүхийг хариуцах болно. Энд зогсогчдын дунд чөлөөтэй орох эрхийг Би чамд соёрхоно. (Зехариа 3:4-7 АБ 2004)

¹Тэр өдөр зугтагч могой Левиатан, мушгиа могой Левиатаныг ЭЗЭН Өөрийн уур хилэн болон их хүчит илдээр шийтгэнэ. Тэр далайн лууг ална.

²Тэр өдөр “Усан үзмийн тариалангийн талбайн тухай дуулагтун.³ЭЗЭН Би түүний хамгаалагч. Би түүнийг эгшин бүрд усалдаг. Хэн ч түүнийг бүү гэмтээг гэсэндээ Би түүнийг өдөр шөнөгүй хамгаална. ⁴Надад хилэн байхгүй. Нохойн хошуу, эсвэл өргөсийг Миний эсрэг тулалдуулахаар босговол Би тэднийг гишгэж, нэгмөсөн шатаах байсан. ⁵Эсвэл тэр Миний хамгаалалтад түшиг. Тэр Надтай энхийг тогтоог. Тэр Надтай энхийг тогтоог”.

⁶Ирэх өдрүүдэд Иаков үндэслэж, Израиль нахиалан цэцэглээд, бүх ертөнцийг жимсээр дүүргэнэ.⁷Түүнийг цохисон хүмүүсийг цохисон шиг Тэр түүнийг цохисон уу? Түүнийг алсан тэд алагдсан шиг тэр бас алагдсан уу? ⁸Та түүнийг няцаахдаа зөв хэмжүүрээр шийтгэж, дорнын салхитай өдрийнх мэт түүнийг догшин салхиараа авч явна.

⁹Үүгээр Иаковын нүгэл нь уучлагдана.Энэ нь түүний нүглийг зайлуулсны бүх үр дүн болно. Тэрээр тахилын ширээний бүх чулууг бутарсан шохойн чулуу мэт болгоход Ашерагийн

модон шон болон утлагын тахилын ширээ тогтохгүй.
¹⁰Бэхлэгдсэн хотууд хоосорч, эдлэн газар нь цөл мэт мартагдана. Тэнд тугал бэлчин, мөн хэвтэж, мөчрүүдийг нь иднэ.

¹¹Түүний мөчрүүд хатаж хугарахад, эмэгтэйчүүд ирж, тэднээр гал асаана. Учир нь тэд ялгах чадваргүй хүмүүс билээ. Тиймээс Хийгч нь тэднийг үл өршөөж, Бүтээгч нь тэднийг нигүүлсэхгүй. (Исаиа 27:1- 11 АБ 2004)

[] Таны нүгэл нэг өдрийн дотор зайлуулагдсан гэдэгт та итгэдэг үү?

[] Та нүглүүдийнхээ ачааг үүрдэг үү?

19.6 Ачааллыг арилгасан

²⁷Тэр өдөр тэдний дарамтыг мөрнөөс чинь, буулгыг нь хүзүүн дээрээс чинь зайлуулна. Таргалснаас болж, буулга нь эвдэрнэ. ²⁸Тэр Аиатад ирж, Мигроноор дамжин Михмашт нөөцөө хадгална. ²⁹Тэд давааг даваад “Бид Гебад хоноглох болно” гэв. Рама түгшиж, Саулын Гибеа зугтав. ³⁰Галлимьн охид оо. Бүх дуугаараа чанга хашхирцгаа! Анхаарагтун, Лаиша. Хөөрхийлөлтэй Анатот оо! ³¹Мадмена зугтаж, Гебимийн оршин суугчид хоргодох газар хайв. (Исаиа 10:27-31 АБ 2004)

[] Өчигдөр ч, өнөөдөр ч хэвээрээ байдаг Бурхан таныг хамаалдаг гэдгийг та мэдэх үү?

19.7 Зөв шударга хүмүүсийн төгсгөл

²²Үхвэл зохих нүгэл үйлдсэн хүнийг алж, түүнийг модонд өлгөвөл ²³хүүрийг нь модон дээр шөнөжин байлгаж болохгүй. Түүнийг тэр өдөрт нь булшил. ЭЗЭН Бурханаас чинь та нарт өв болгон өгч буй тэр газрыг бүү бузарла. Модон дээр өлгөгдсөн хүн бол Бурханаар хараагдсан болой. (Дэд хууль 21:22- 23 АБ 2004)

²⁰Баяраар Бурханд мөргөхөөр ирсэн хүмүүсийн дунд хэдэн Грек хүн байлаа. ²¹Тэд Галилын Бетсайдын Филип уруу очиж, түүнээс -Эзэнтэн, бид Есүсийг хармаар байна гэж

гуйсанд ²²Филип явж Андрейд хэлэв. Андрей, Филип нар явж Есүст дуулгав.

²³Есүс тэдэнд -Хүний Хүүгийн алдарших цаг нь ирлээ. ²⁴Үнэнээр, үнэнээр Би та нарт хэлье. Хэрэв улаан буудайн үр газар унаад үхэхгүй бол тэр ганцаараа үлдэнэ. Харин хэрвээ тэр үхвэл олон үр бий болгоно. ²⁵Өөрийн амийг хайрлагч хүн түүнийгээ алдана. Энэ ертөнцөд өөрийн амийг үзэн яддаг хүн түүнийгээ мөнх аминд хүртэл хамгаалах болно. ²⁶Хэрэв Надад үйлчлэх хүн байвал, Намайг дага. Хаана Би байна, тэнд бас Миний зарц байх болно. Хэрэв хүн Надад үйлчилбэл, тэр хүнийг Эцэг минь хүндэлнэ. ²⁷Одоо сэтгэл минь шаналж байна. Би юу гэж хэлэх юм бэ? “Аав аа, энэ цагаас Намайг авраач” гэх үү? Гэвч Би энэ зорилгын төлөө энэ цагт л ирсэн. ²⁸Аав аа, нэрээ алдаршуулаач гэв. Тэгтэл тэнгэрээс -Би нэрээ алдаршуулсан. Дахин алдаршуулна гэсэн дуу гарлаа. ²⁹Тэнд зогсож байсан хүмүүс үүнийг сонсоод -Тэнгэр дуугарлаа гэхэд зарим нь -Тэнгэр элч Түүнтэй ярилаа гэцгээв.

³⁰Есүс -Энэ дуу Миний төлөө биш, харин та нарын төлөө гарсан. ³¹Одоо энэ ертөнц шүүгдэх гэж байна. Одоо энэ ертөнцийн захирагч зайлуулагдах болно. ³²Хэрэв Би газраас өргөгдвөл, бүх хүнийг Өөртөө татна хэмээн айлдлаа. ³³Тэр Өөрөө ямар үхлээр үхэхээ онцолж үүнийг хэлжээ.

³⁴Хурсан олон Түүнд -Христ мөнхөд байна гэж бид хуулиас сонссон атал Та “Хүний Хүү өргөгдөх ёстой” гэж яаж ярьж чадна вэ? Энэ Хүний Хүү нь хэн бэ? гэв. ³⁵Есүс тэдэнд -Хоромхон хугацаанд гэрэл нь та нарын дунд байна. Та нарыг харанхуй нөмрөн авахгүйн тулд гэрэлтэй байх зуураа явагтун. Харанхуйд явагч хүн хаашаа яваагаа мэдэхгүй. ³⁶Гэрэлтэй байх зуураа та нар гэрэлд итгэгтүн. Тэгвэл та нар гэрлийн хөвгүүд болно гэлээ. Есүс ийн айлдсаны дараа тэднээс салан явж нуугдав. (Иохан 12:20- 36 АБ 2004)